

АГУУЛГЫН ЗОХИЦУУЛАЛТ

1998 онд батлагдсан Монгол Улсын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “ ... Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй.”, 3.2-т “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.” гэж төрийн хийх ёсгүй зүйлийг тогтоож, хязгаарлаж өгсөн юм. Өнөөдрийн байдлаар Монголын Төр засаг хуулийн уг заалтыг ноцтой зөрчсөн зүйл ажиглагдаагүй л байна.

Хэвлэл мэдээллийн агуулгад бүрэн хэмжээгээр хяналт, цензур тавьдаг, ийм чиг үүрэг бүхий төрийн албан ёсны байгууллага байхгүй. Бид ямар ч байсан Төрийн байгууллагаар олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тавиулахгүй гэж шийдсэн, хуультай болсон. Энэ бол нэг том дэвшил юм. Гэхдээ энэ нь олон нийтийн мэдээллийн агуулга ямар ч хяналт, хязгаарлалтгүй болсон гэсэн үг биш болов уу. Мэдээллийн агуулгадаа ёс зүй, ёс суртахууны зүй ёсны хяналт, хязгаарлалт хийх үүрэг Хэвлэлд өөрт нь шилжсэн гэж бодож байна.

Өнөөдөр Төр засаг мэдээлэл хянах байгууллага байгуулаагүй ч гэсэн, хууль тогтоомж гаргах замаар олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт, шалгуур, хязгаарлалт тавьж байгаа нь үнэн. Өнөөдөр хуулиар тогтоосон олон нийтийн мэдээлэл дэхь хяналт, хязгаарлалт бүрэн утгаараа хэрэгжиж байна уу гэвэл үгүй. Монголд хууль хэрэгждэггүй сул тал нь хэвлэлийн эрх чөлөөний хувьд давуу тал болж олон нийтийн мэдээллийн агуулгад дахь хуулиар тогтоосон хязгаарлалт тийм ч их хүчтэй биш байна.

Эрх зүйн хувьд олон нийтийн мэдээллийн агуулгад ёс суртахууны болон зүй ёсны хязгаарлалт байх нь ойлгомжтой зүйл юм. Энэ ч утгаараа Монгол Улсын Эрүүгийн хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Соёлын тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хэд хэдэн хуулиар мэдээллийн агуулгад хязгаарлалт тогтоосон байна. Гэхдээ агуулгын хязгаарлалт, зохицуулалт цэгцтэй, зохистой биш, бас хэрэгжихгүй байна.

Манай Улсад мэдээлэл ил тод, нээлттэй биш, мэдээлэл олж авах хууль зүй боломж хязгаарлагдмал гээд шалгуур тавиад үзэхээр Монгол дахь Хэвлэл мэдээллийн эрх чөлөө бол 20 жилийн хугацаанд хагас дутуу хөгжсөн эрх чөлөөний тоонд орно, нөгөө талаар энэ эрх чөлөөний далбаа нь дор олон нийтэд түгж буй зарим нэг мэдээллийн агуулга хүмүүсийн сэтгэл эмзэглүүлж байгаа нь бодитой үнэн. Бид чинь ТВ-ийн чатаар дамжуулж хүн алах захиалга өгч байгааг үзэж л байдаг, мөн чатаар дамжуулан биеэ үнэлж байгааг гэртээ хараад суудаг болсон шүү дээ.

Энэ бодит байдал бол бид олон нийтийн мэдээллийн агуулгад тавигдах ёстой ёс суртахуун, зүй ёсны хязгаарлалтын төвшин, хэмжээгээ бодитой тогтоож чадаагүй, хязгаарлавал зохих зүйлээ хязгаарлаж чадахаа больсон, хуулиар зохицуулж чадах ийм энгийн зүйлээ ч зохицуулах чадваргүй байгааг гэдгийг харуулж байгаа юм.

Олон нийтэд түгж буй нийгмийн ёс суртахуунд буруу, муу тусгалтай зарим мэдээллийн агуулгад хууль зүйн болон техникийн зохицуулалт дутмаг байгаа юм. Мэдээллийн агуулга дахь эрх зүй зохицуулалтын гол үүрэг бол хязгаарлавал зохих мэдээллийг шүүж чаддаг, хязгаарлаж чаддаг байх явдал юм. Манай Улсад Мэдээллийн эрх чөлөөний баталгаа, хамгаалалт, нөгөө талаар хязгаарлах ёстой зохих зүйлийн зохицуулалт аль алин нь зохицуулалт сул, цаг үетэйгээ нийцэхгүй, байнга л хоцорсон байдаг.

Саяхан болсон бодитой нэг жишээ дурдаж болно. Хүний нэр төр, алдар хүнд гэдэг бол вэб сайтын зочны сэтгэгдэл дарлагдаж, гутаагдаж өнөөдрийг хүрлээ. Үүний төлөө хэн ч юу ч хийхгүй байна. Бид өнгөрсөн 20 жилд Хэвлэлийн эрх чөлөө гэдэг нь хүний нэр төрд халдах эрхтэй байдаг юм байна гэж ойлгож ирсэн, гэтэл энэ нь үгүй юм байна. Нээлттэй, ардчилсан нийгмийн гол зарчим нь хувь хүнийг дээдлэх үзэл шүү дээ.

УИХ-ын нэгэн эрхэм гишүүний улс төрийн үйл ажиллагаатай холбогдуулан Монголын нэгэн томоохон мэдээллийн портал сайтад мэдэгдэл тавигдсан байдаг, үүнийг нь уншсан зочин сэтгэгдлээ үлдээсэн байдаг. Интернэтээр аялаж яваа зочид маань сэтгэгдлээ үлдээхдээ “ ... лалар ... алуурчин ... мэлхий шиг ... хулгайч ... ” гээд нэр төрийг нь гутаана гэхэд арай дэндэхээр бөөн юм үлдээсэн. Зочины бичсэн сэтгэгдэл улс орон даяар, дэлхий даяар цацагдсан, олон ч хүн үзсэн, үүний дотор нөгөө УИХ-ын гишүүний ач гуч, үр хүүхэд нь ч уншсан.

Иймхэн зүйл бичихийн төлөө эрх чөлөө олгосон юм уу, энэ бичсэн зүйл нь эрх чөлөө мөн үү гэдэг асуулт гарч ирээд байна. Хөндлөнгөөс харахад юун сүртэй юм бэ, байдаг л зүйл шүү дээ гэж бид бодож байдаг, тэгвэл тэр нэр төрөө гутаалгасан хүний оронд өөрийгөө тавиад үз.

Мэдээллийн агуулга, агуулгын эрх зүйн зохицуулалт гэдэг бол маш өргөн хүрээтэй, онцгой ач холбогдолтой зүйл, үүнд зүй ёсны хязгаарлалт, зохицуулалт зайлшгүй шаардлагатай, зүй ёсны хязгаарлалт дутагдвал Хэвлэлийн эрх чөлөө аюулд орно.

Энэ асуудал хувь хүний нэр төр, алдар хүндийг гутаах, сэргээх тухай асуудал биш, Үндэсний аюулгүй байдлыг хөндөх хэмжээнд хүрчээ. Тийм ч учраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.1.2-т “Нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг хязгаарлана.” гэж заажээ.